

**“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай
хуульд заасан урьдчилан шийдвэрлэх
ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх”
хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний
тайлан**

Улаанбаатар
2021 он

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	2
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	3
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	3
1.2. Үнэлгээ хийх хүрээ.....	3
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	4
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	4
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох.....	5
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	6
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	7
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	9
3.1. Дүгнэлт гаргахад учирсан хүндрэлтэй нөхцөл байдал	9
3.2. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа	10
3.3. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт.....	14
3.4. Эвлэрүүлэн зуучлагчийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт ...	18
3.5. Санхүүгийн зохицуулах хорооны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт.....	23
ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ	30
ТАВ. ЗӨВЛӨМЖ, САНАЛ.....	32
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	33
ХАВСРАЛТ	34

УДИРТГАЛ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засаг хөгжлийн яамны захиалгаар Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд хийгдэж буй “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

Тус үнэлгээг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн ухааны доктор Д.Гангабаатар ахалж, Өмгөөллийн “БЭЗ Партнерс” ХХН-ийн гишүүн, хуульч Л.Загдаа, хуульч Б.Түвшинжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2-д “Энэ хуулийн 3.1-д заасан эрхийг хамгаалах талаарх нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно.” гэж заасны дагуу Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Даатгалын тухай хуульд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх маргааныг зохицуулсан байдаг. Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдаж, 1999 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд 22 жил, Даатгалын тухай хууль 2004 онд батлагдаж, 2005 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд 17 жил болжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан.

Иймд дээрх хууль тогтоомжид заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хуулийн зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ хийх шаардлага Хууль тогтоомжийн тухай хуулиар үүссэн байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна.

2002 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2-д “Энэ хуулийн 3.1-д заасан эрхийг хамгаалах талаарх нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно.” гэж заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1, 126.1-д хөдөлмөрийн маргаан таслах комисс, Даатгалын тухай хуулийн 82.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Гэр бүлийн тухай хуулийн 14.1-д зааснаар эвлэрүүлэн зуучлагч нар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийхээр зохицуулагджээ. Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд

хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5-д “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ” гэж заасан байдаг.

Дээрх зохицуулалтын дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хуульд зааснаар заавал хийгдсэн байхыг шаардах 4 төрлийн маргааныг тодорхойлж болохуйц байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн маргаан
2. Гэр бүлийн маргаан
3. Даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан
4. Гэрээндээ эвлэрүүлэн зуучлагчид хандахаар заасан маргаан

Тус маргаануудыг урьдчилан шийдвэрлэж байгаа субъект, урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах онцлог, хуулийн зохицуулалт, тулгарч буй асуудлыг судлан тогтоосны үндсэн дээр хуулийн зохицуулалтад үнэлгээ хийхийг зорьсон болно.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

Аргачлалын 3.4.4-д заасан “хүлээн зөвшөөрөгдсөн байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг тогтооно.

Аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. “байх ёстой болон одоо байгаа байдал”, мөн 3.5.3.4. “тохиолдол судлах” хэлбэрүүдийг сонголоо. Учир нь, одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохын тулд “байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг хэрэглэхээр заасан байна. Бид үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтуудын хувьд “зорилгод хүрсэн түвшин”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгахар тогтоосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгосон болно.

Мөн үнэлгээний хүрээгээр тогтоосон урьдчилан шийдвэрлэх ажиллагааны талаарх үндсэн заалт нь Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Даатгалын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд харин урьдчилан шийдвэрлэх ажиллагааны процесс ажиллагаа нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмээр тодорхойлогддог. Иймд “тохиолдол судлах харьцуулах” хэлбэрийг сонгон, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хуулийн зохицуулалтуудыг өөр хооронд харьцуулан судлах нь тус хуулийн зохицуулалтуудыг сайжруулахад зайлшгүй хийгдэх ёстой судалгаа гэж үзлээ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэхүү үнэлгээг хийхэд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал болон хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан болно. Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах асуултуудыг боловсрууллаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны гол зорилго нь шүүхийн ачааллыг бууруулах буюу урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрөх явдал юм. Иймд **“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дах хэсэг. Энэ хуулийн 3.1-д заасан эрхийг хамгаалах талаарх нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?
- Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх тутам хянан шийдвэрлэнэ гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?
- Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?
- Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно гэсэн зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх?

Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрлэсэн шийдвэрийг талууд талууд хүлээн зөвшөөрч биелүүлсэн эсэх?
- Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнтэй болсон эсэх? Хэдэн хувь нь үр дүнтэй байдаг эсэх?

- Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Зохицуулах хорооны шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрдөг эсэх? Хэдэн хувь нь шийдвэрт гомдол гаргадаг эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс хянан шийдвэрлэж байгаа эсэх
- Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж буй байдал, түүнд тулгарч буй асуудал байгаа эсэх
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5-д “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ гэсэн заалтын дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн эсэх?
- Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлсэн байдал, маргаан шийдвэрлэхэд тулгарч буй асуудал байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, судлах, харьцуулалт хийх, мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцах, санал солилцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах дараахь аргуудыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: ИХШХШтХ дахь урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан холбогдох хууль тогтоомж болох ХтХ, ГБтХ, ДтХ, СЗХЭЗБтХ, ЭЗтХ болон бусад эрх зүйн баримт бичиг, ном сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистик мэдээнд дүн шинжилгээ хийсэн.
- Аргачлалын 3.7.3.2-т заасны дагуу Холбогдох субъектээс судалгаа авах: Гэр бүлийн эрх зүйн харилцаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийж байгаа эвлэрүүлэн зуучлагч нараас ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа мэдээллийг цуглуулах, шүүх, холбогдох субъектээс судалгаа авах аргаар холбогдох материалыг цуглуулан үнэлгээ хийсэн болно.

Нэг. Хууль, эрх зүйн акт

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
- Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
- Гэр бүлийн тухай хууль, 1999 он
- Даатгалын тухай хууль, 2004 он
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2012 он
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он
- “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”, Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 2-р хавсралт

Хоёр. Судалгааны мэдээ, судалгааны тайлан, ном

- Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn/-гийн Даатгалын маргаанд холбогдох шийдвэрүүд /2019.01.01-ний өдрөөс 2021.08.23-ны өдрийн байдлаар/
- Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn/-гийн Хөдөлмөрийн маргаанд холбогдох шийдвэрүүд /2019.01.01-ний өдрөөс 2021.08.23-ны өдрийн байдлаар/
- Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгосон тэмдэглэл” /2019, 2020, 2021 оны/
- Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамж /2019, 2020, 2021 оны/
- Монгол улсын шүүхийн 2018 оны тайлан
- Монгол улсын шүүхийн 2019 оны тайлан
- Монгол улсын шүүхийн 2020 оны тайлан
- Монгол улсын шүүхийн 2021 оны хагас жилийн тайлан
- Санхүүгийн зохицуулах хороо- 2017 оны өргөдлийн судалгаа
- Санхүүгийн зохицуулах хороо- 2018 оны өргөдлийн судалгаа
- Санхүүгийн зохицуулах хороо- 2019 оны өргөдлийн судалгаа

Гурав. Цахим эх сурвалж

- <http://opendata.burtgel.gov.mn>
- <http://www.frc.mn>
- <https://www.iudcouncil.mn/>
- www.shuukh.mn

Дөрөв. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа тус бүрт хийгдсэн дүн шинжилгээ болон хавсралтад шүүхийн шийдвэрийн дүгнэлтийг тусгасан болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Дүгнэлт гаргахад учирсан хүндрэлтэй нөхцөл байдал

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь практикт шийдэгдсэн хэрэг, маргааны шийдвэр дээр дүн шинжилгээ хийх замаар гүйцэтгэх боломжтой ажиллагаа болно.
2. Дээрх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн төрөлжсөн архив, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхүүд тус тус хүсэлт гаргаж, урьдчилан шийдвэрлэх ажиллагааг баталгаажуулсан шүүхийн шийдвэртэй судалгааны зорилгоор танилцах хүсэлт гаргасан.
3. Гэвч аливаа шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн болон урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдэгдсэн хэрэг дээр гаргаж буй шүүгчийн захирамжуудын хувьд тусгайлан ялгасан дугаарлалт байхгүй байгаагаас шалтгаалж уг үнэлгээний ажилд холбогдох шийдвэрүүдийг салган авч танилцах боломж байхгүй байсан болно.
4. Шүүхүүдийн зүгээс шүүхийн ачаалал их байгаа болон зарим шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн хувьд нууцад хамаарах нотлох баримт тусгагдсан, хуулиар хаалттай явагдсан хурал зэрэг шалтгааны улмаас шийдвэрдлэгдсэн хэргийн материал болон шүүхийн шийдвэр, захирамжтай танилцах боломжгүй гэж өгсөн болно.
5. Иймд судлаачийн зүгээс шүүхийн цахим санд нээлттэй байршсан хэргүүдээс түүвэрлэх байдлаар дүгнэлт гаргах, шүүхийн ачаалал бага буюу орон нутгийн шүүхийн зарим хэргийн материалтай танилцах байдлаар уг үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.
6. Цаашид энэ төрлийн судалгааг гүйцэтгэхэд шүүхийн тогтоол, шийдвэр, шүүгчийн захирамжийн хувьд урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдэгдсэн хэрэг болон хялбаршуулсан журмаар шийдсэн хэргүүдийг ялгасан, ангилсан байдлаар гарсан тохиолдолд илүү өргөн хүрээнд хийж гүйцэтгэх боломжтой.

3.2. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө хуульд заасны дагуу өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалж харьяалах газарт нь гомдол гаргах, гомдлоо шийдвэрлүүлэхийг хэлнэ. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхээр заасан маргаан дээр талууд шууд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй байдаг. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д “шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал” гэж заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлд хамаардаг.

Монгол улсад Захиргааны эрх зүй болон Иргэний эрх зүйд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэх ойлголт байдаг. Захиргааны эрх зүйн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллагын дээд шатны байгууллагад гомдол гаргах замаар хэрэгждэг бол Иргэний эрх зүйд хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэгжихээр зохицуулсан байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2-д “Энэ хуулийн 3.1-д заасан эрхийг хамгаалах талаарх нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, тодорхой төрлийн харилцааг зохицуулсан органик хуульд маргааныг шүүхээс өмнө өөр байгууллага урьдчилан шийдвэрлэхээр заасан байж болно. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1, 126.1-д хөдөлмөрийн маргаан таслах комисс, Даатгалын тухай хуулийн 82.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Гэр бүлийн тухай хуулийн 14.1-д зааснаар эвлэрүүлэн зуучлагч нар урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу хийдэг. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5-д “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ” гэж заасан байдаг.

Гэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлд хамаарах маргааны төрөлд Гэрлэлт цуцлах маргаан, Даатгалын үйл ажиллагаанд холбогдох маргаан, Гэрээндээ эвлэрүүлэн зуучлагчид хандахаар заасан маргаан хамаарна. Харин тодорхой төрлийн хөдөлмөрийн маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхээр Хөдөлмөрийн тухай хуульд заагдсан байдаг ч практикт урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах субъект нь байдаггүй тул шүүх нэхэмжлэлийг шууд хүлээн авч шийдвэрлэж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хийж буй субъектыг тодорхойлвол:

1. Эвлэрүүлэн зуучлах газар
2. Санхүүгийн зохицуулах хороо
3. Хөдөлмөрийн маргаан таслах комисс

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгддэг маргааны төрлийг тодорхойлвол:

1. Гэрлэлт цуцлахтай холбоотой гэр бүлийн маргаан
2. Гэрээндээ эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр заасан гэрээний маргаан
3. Даатгалын үйл ажиллагаатай холбогдох маргаан
4. Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1-д зааснаас бусад хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан

Хуулийн зохицуулалтын харьцуулбал:

№	Хуулийн нэр	УША-ны зохицуулалт	УША-нд хамаарахгүй тохиолдол
1	Гэр бүлийн тухай хууль	14.1.Энэ хуулийн 13-т зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.	14.4. Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүй байж болдог.
2	Даатгалын тухай хууль	82.1.Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс	82 ¹ .1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ. 82 ¹ .2.Энэ хуулийн 82 ¹ .1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 82 дугаар зүйл

		хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.	хамаарахгүй.
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	13.5.Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ	Гэрээнд заагаагүй бол урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хийгдэхгүй байж болно.
4	Хөдөлмөрийн тухай хууль	125.1.Ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс, шүүх тус тусын харьяаллын дагуу шийдвэрлэнэ. 126.1.Шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх дутам хянан шийдвэрлэнэ.	128.1.Дараах маргааныг шүүхээр хянан шийдвэрлэнэ: 128.1.1.Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг энэ хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу давж заалдсан гомдол; 128.1.2.ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдол; 128.1.3.ажилтнаас хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байхдаа аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл; 128.1.4.хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үед эрүүл мэнд нь хохирсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажилтны нэхэмжлэл; 128.1.5.энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан асуудлаар гарсан маргаан; 128.1.6.иргэн хоорондын

		хөдөлмөрийн гэрээтэй холбогдон гарсан маргаан; 128.1.7.сахилгын шийтгэл буруу ногдуулсан тухай ажилтны гомдол; 128.1.8.хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хууль тогтоомж болон хамтын гэрээнд зааснаас дордуулсан тухай ажилтны нэхэмжлэл; 128.1.9.хөдөлмөрийн дотоод журам хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар өөрийн онцлогт тохируулан тогтоосон байгууллагын бусад тушаал, шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй тухай ажилтны нэхэмжлэл; 128.1.10.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчдын хоорондын хөдөлмөрийн маргаан; 128.1.11.хууль тогтоомжоор шүүхэд харьяалуулсан бусад маргаан.
--	--	--

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны процесс ажиллагааг зохицуулсан байдал:

№	УША явуулах субъект	УША явуулахад мөрдөх хууль тогтоомж, дүрэм журам
1	Эвлэрүүлэн зуучлагч	Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль /2012 он/
2	Санхүүгийн зохицуулах хороо	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль /2005 он/
3	Хөдөлмөрийн маргаан таслах комисс	Засгийн газрын 122 тогтоолын 2-р хавсралт: “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”

3.3. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт

Хөдөлмөрийн тухай хууль нь 1999 онд батлагдан мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд нийт 24 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Гэхдээ хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх тутам хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд шууд шүүхэд хандах маргааны төрлийг тоочих хэлбэрээр зааж өгсөн бөгөөд бусад хөдөлмөрийн маргаан нь мөн хуулийн 125.1, 126.1-д заасны дагуу анх тутам хөдөлмөрийн маргаан таслах комиссоор шийдвэрлэгдэхээр зохицуулагдсан байдаг. Харин Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”-ийн 2-д *«Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгж, байгууллагын дэргэд хөдөлмөрийн маргаан таслах комисс /цаашид "комисс" гэнэ/ байгуулж ажиллуулна»* гэж заасны дагуу МУ-д үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуй нэгж буюу улсын бүртгэлд бүртгэлтэй 217 794¹ хуулийн этгээд дэргэдээ хөдөлмөрийн маргаан таслах комисстой байхаар байна. Гэтэл улсын бүртгэлд бүртгэлтэй 217 794 хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулдаггүй, ажилтан, албан хаагч байхгүй хуулийн этгээд цөөнгүй байдаг. Түүнчлэн уг хууль болон Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байгууллага байхгүй, хэдэн хуулийн этгээд дэргэдээ хуульд заасны дагуу маргаан таслах комисс байгуулсан талаарх тоо мэдээлэл, судалгаа, бүртгэл огт байхгүй байна. Өөрөөр хэлбэл, хуулиараа шүүхэд шууд хандахаас бусад хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий субъект болох Хөдөлмөрийн маргаан таслах комисс нь тухайн байгууллагад байдаг эсэх, түүнийг хянах боломж шүүхэд байдаггүй. Нөгөө талаас нэгэнт байгуулагдаагүй хөдөлмөрийн маргаан таслах комисс урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаа явуулах боломжгүй тул нэхэмжлэл гаргагч иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс Иргэний шүүх тус урьдчилан шийдвэрлэх ажиллагааг заавал хийгдсэн байхыг шаардалгүй хүлээн авч иргэний хэрэг үүсгэн шийдвэрлэдэг. Тухайлбал,

Тохиолдол 1. Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 сарын 05-ны өдрийн 152/ШШ2021/00110 тоот шийдвэрт:²

Нэхэмжлэгч иргэн “... Би хөдөлмөрийн маргаан таслах комисст хандаагүй, Улаангом сумын Засаг даргын Тамгын газарт хөдөлмөрийн маргаан таслах комисс ажилладаг эсэхийг мэдэхгүй ...” гэж нэхэмжлэлдээ бичсэн бол Шүүх

¹ <http://opendata.burtgel.gov.mn/les>

² https://shuukh.mn/single_case/101373?daterange=2019-01-01%20-%202021-08-22&id=1&court_cat=1&bb=1&fbclid=IwAR14x59qhMlcUaH01OLdRXYoJxEcb4yQjo4KTx_igkB30wuL_Gzo_ivFcQVU

шийдвэрийн үндэслэх хэсэгтээ “... Увс аймгийн Улаангом сумын Засаг даргын Тамгын газарт хөдөлмөрийн маргаан таслах комисс байхгүй болох нь Увс аймгийн Улаангом сумын Засаг даргаас 2021 оны 03 сарын 05-ны өдөр ирүүлсэн тодорхойлолтоор тогтоогджээ. Иймд О-ийн нэхэмжлэлтэй, УАУГСЗДТГ-т холбогдох иргэний хэргийг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журам хэрэглэхгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн болно” гэж дурдаж, хэргийг шийдвэрлэсэн байна.

Тохиолдол 2. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 14-ний өдрийн 01170 дугаартай шийдвэр³:

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “... Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГазар нь хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулаагүй болох нь тус байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооны 2016-01-16-ны өдрийн 30 дугаартай албан бичгээр /1-р хх-19/ тогтоогдож байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасан урьдчилсан нөхцлийг зөрчөөгүй байх тул уг иргэний хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр байна. тухайн байгууллагад хөдөлмөрийн маргаан таслах комисс байхгүй тохиолдолд ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны талаар шүүхэд хандахаар байна.” гэж тус тус дурдан, хэргийг шийдвэрлэсэн байна.

Тохиолдол 3. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 сарын 26-ны өдрийн 182/ШШ2020/00605 дугаар шийдвэр⁴-т:

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Хөдөлмөрийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1, 128 дугаар зүйлийн 128.1-д заасан агуулгаас үзэхэд ажилласан үеийн цалин гаргуулах маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх хянан шийдвэрлэхээр байх боловч тухайн байгууллагад хөдөлмөрийн маргаан таслах комисс байхгүй тохиолдолд шүүх маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж дурдаж, хэргийг шийдвэрлэсэн байна.

Харин тухайн байгууллагад маргаан таслах комисс байгаа бол урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэний үндсэн дээр шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой юм. Тухайлбал,

Тохиолдол 4. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 09 сарын 24-ний өдрийн 182/ШШ2019/01603 дугаар шийдвэр⁵-т:

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: “... ажилчдын зүгээс 2019.04.18-ны өдөр Хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулан хуралдуулж, уг хурлаас

³https://shuukh.mn/single_case/94348?daterange=2019-01-01%20-%202021-08-24&id=1&court_cat=1&bb=1

⁴https://shuukh.mn/single_case/91998?daterange=2020-01-01%20-%202020-12-24&id=1&court_cat=1&bb=1

⁵https://shuukh.mn/single_case/87775?daterange=2019-01-01%20-%202021-08-23&id=1&court_cat=1&bb=1&fbclid=IwAR2W1_CMpdTB8fllqP9Ado2mtkmvVqg-QL6ShreFtK5SarYWEDRjoHiiFGM

Капитал банкны эрх хүлээн авагчид контрактын гэрээтэй ажилтнуудад тэтгэмж олгуулах болон бусад асуудлын талаар албан шаардлага хүргүүлжээ. ...” гэж дурдаж, хөдөлмөрийн маргаан таслах комиссоор маргааныг урьдчилан шийдвэрлүүлсэн гэж үзсэн байна.

Тохиолдол 5. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 сарын 10-ны өдрийн 182/ШШ2020/00526 дугаар шийдвэр⁶-т:

Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ “... ажилласан хугацааны цалин хөлс олгохгүй, ажлаас халсан шийдвэрийг өгөхгүй, ажил үүргийг гүйцэтгүүлэхгүй байсан учраас Хөдөлмөрийн маргаан таслах шуурхай зөвлөлд гомдол гаргасан боловч “шүүхээр шийдвэрлүүлэх” гэсэн хариу өгсөн. Мөн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт хандахад “Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд хамаарах шүүхээр хянан шийдвэрлэх маргаан тул харьяа дүүргийн шүүхэд хандан шийдвэрлүүл гэсэн хариу өгсөн” гэж, харин шүүх үндэслэх хэсэгтээ урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн учраас дүгнэлт хийгээгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга:

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээр байгаа билээ. Тус шинэчилсэн найруулгад дараах байдлаар нэр томъёог дараах байдлаар өөрчлөн тусгасан байна.

1. Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг “Хөдөлмөрийн эрхийн маргаан” гэж
2. Хөдөлмөрийн маргаан таслах комиссыг “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс” гэжээ.

Мөн 1999 оны Хөдөлмөрийн тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарсан зөрчил, дутагдлыг арилгаж, урьдчилан шийдвэрлэх ажиллагааг дүнтэй болгох шинэлэг зохицуулалтууд тусгагдсан байна. Тухайлбал,

1. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс байхгүй бол “сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо” урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулахаар байна.
2. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд гомдол гаргаж шийдвэрлүүлэхээр байна. Уг хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээгдэнэ.
3. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг 20 болон түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж байгуулна гэж заасан үүрэгжүүлсэн бол 20-с доош ажилтантай байгууллага нь хөдөлмөрийн эрхийн маргаан таслах

⁶https://shuukh.mn/single_case/91282?daterange=2019-01-01%20-%202021-08-23&id=1&court_cat=1&bb=1&fbclid=IwAR0OuG9yw9bN7yzTQpfBbTHhfOiC_oNx3jrUWz333FolG-NUuc6jC4JC_qk

комиссыг байгуулж болно гэж зөвшөөрсөн байна.

4. Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо хөдөлмөрийн эрхийн маргааныг хянан шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор талууд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол уг шийдвэрийг талууд заавал биелүүлэх үүрэгтэй байх төдийгүй уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш маргалдагч аль нэг тал ажлын таван өдөрт багтаан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болохоор заажээ.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад хүчин төгөлдөр болсон хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс болон гурван талт хорооны тэмдэглэл, шийдвэрийг шүүхээр баталгаажуулах боломжтой болж байгаа нь нөгөө тал биелүүлэхгүй тохиолдолд албадан гүйцэтгүүлэх боломжийг бий болгосон үр дүнтэй зохицуулалт болжээ.

Шинэ болон хуучин хуулийн харьцуулалтыг хавсралт 1-ээс үзэх боломжтой.

Дүгнэлт: Шүүхэд хандахаар заагаагүй хөдөлмөрийн ганцаарчилсан маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхээр зохицуулагдаж, тухайн байгууллагын хөдөлмөрийн маргаан таслах комисс хянан шийдвэрлэхээр заан, Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолоор маргаан таслах комиссыг хэрхэн байгуулах, хэрхэн ажиллах талаар зохицуулсан “Хөдөлмөрийн маргаан таслан комиссын дүрэм”-ийг баталсан хэдий ч бодит байдал дээр тус хуулийн заалт, дүрэм бүрэн хэрэгжээгүй байна. Учир нь хувийн болон төрийн байгууллагад хөдөлмөрийн маргаан таслах комисс дийлэнх тохиолдолд байдаггүй, түүнийг хянадаг байгууллага байхгүй тул Хөдөлмөрийн тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт хэрэгждэггүй ажээ. Иргэний хэргийн шүүхийн зүгээс хөдөлмөрийн маргаан таслах комисс байдаг, байдаггүйд хяналт тавих боломжгүй учраас тус хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг заавал хийгдсэн байхыг шаарддаггүй, нэхэмжлэлийн хүлээн авч шийдвэрлэдэг. Энэ нь иргэний Монгол улсын Үндсэн хуульд заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах ...” үндсэн эрхийг хамгаалах үйл ажиллагаа болно. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хуучин хуулийн зохицуулалтыг илүү дэлгэрүүлж, нарийвчлан тусгасан бөгөөд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийсэн субъектийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулж, албадан гүйцэтгүүлэх боломжийг хангаж өгсөн нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэлэг зохицуулалт болсон байна.

3.4.Эвлэрүүлэн зуучлагчийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Энэ хуулийн 13-т зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.” гэж заасан. Тус хуульд заасан гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүй байдал гэдэгт гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан байдлыг хамааруулж үздэг. Бусад тохиолдолд гэрлэлт цуцлах маргааныг эвлэрүүлэн зуучлалд хандаж урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэний дараа шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээгдэнэ. Хуульд зааснаар гэрлэлт цуцлах маргаан нь урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэний дараа шүүхэд нэхэмжлэл гаргаж, иргэний хэрэг үүсгэдэг ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2-д зааснаар иргэний хэрэг үүсгэсний дараа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулж болдог зохицуулалттай.

Гэрлэлт цуцлах маргаанд шүүх болон эвлэрүүлэн зуучлагчийн зүгээс эхнэр, нөхрийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авдаг.

Эвлэрүүлэн зуучлагч нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан Эвлэрүүлэх зуучлах ажиллагааны журмыг баримтлан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

Тохиолдол 1 Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан 2021 оны 04 сарын 19-ны өдрийн 35 тоот эвлэрлийн гэрээнд: “Өргөдөл гаргагч болон тайлбар гаргагч нар нь харилцан ярилцаад, эргэн эвлэрч, хамтран амьдаръя” гэжээ. Тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулсан байна.

Тохиолдол 2 Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан 2019 оны 05 сарын 09-ний өдрийн 34 тоот эвлэрлийн гэрээнд: “Өргөдөл гаргагч болон тайлбар гаргагч нар нь харилцан ярилцаад, эргэн эвлэрч, хамтран амьдаръя” гэжээ. Тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулсан байна.

Тохиолдол 3. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн 2020 оны 03 сарын 20-ны өдрийн 07 тоот Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тэмдэглэлд:

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны анхны уулзалтыг хийсэн боловч өргөдөл гаргагч нь шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч эвлэрүүлэн зуучлалд ханд гэсэн учраас хандсан, эвлэрэх боломжгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгож өгнө үү гэсэн хүсэлтийг, тайлбар гаргагч нь 2014 оноос хойш тусдаа амьдрах болсон, цаашид хамтран амьдрах боломжгүй тул эвлэрүүлэн зуучлах

ажиллагааг дуусгавар болгож өгнө үү гэсэн тайлбарыг тус тус гаргаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгосон байна.

Тохиолдол 4. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн 2019 оны 03 сарын 29-ний өдрийн 011 тоот Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тэмдэглэлд:

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад 3 удаа уулзалтыг хийсэн боловч өргөдөл гаргагч нь эвлэрэх боломжгүй, гэрлэлтээ цуцлуулна, наашаа цаашаа явах унааны зардал байхгүй учраас эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгож өгнө үү гэсэн хүсэлтийг, тайлбар гаргагч нь эвлэрэх боломжгүй, асуудлаа шүүхээр шийдвэрлүүлнэ, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгож өгнө үү гэсэн тайлбарыг тус тус гаргаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгосон байна.

Тохиолдол 5. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн 2021 оны 01 сарын 14-ний өдрийн 03 тоот Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тэмдэглэлд:

Өргөдөл гаргагч нь Өвөрхангай аймгийн Хархорин суманд хөл хорионд орсон тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уулзалтыг хийж чадаагүй, өргөдөл гаргагч нь эвлэрэх боломжгүй, ажиллагаа хийгээд ямар ч өөрчлөлт гарахгүй, очих боломжгүй, эвлэрлийн ажиллагааг дуусгавар болгож өгнө үү гэсэн хүсэлтийг гаргасан бөгөөд хуульд заасан хугацаа дуусгавар болсон тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгосон байна.

1 . Шүүхийн дэргэдэх Эвлэрүүлэх зуучлах ажиллагааны талаарх мэдээлэл

А. Хүлээн авсан нэхэмжлэл, өргөдөл:

№	Хүлээн авсан нэхэмжлэл, өргөдөл	2018 ⁷	2019 ⁸	2020 ⁹	2021 /хагас жил/ ¹⁰
1	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд шууд хандсан	15578	17284	21871	9952
2	Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлсэн	53	5	1	3
3	Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлсэн	398	428	468	222
Нийт		16029	17717	22078	9952

Б. Өргөдөл, нэхэмжлэлийн шийдвэрлэлт:

⁷ Монгол улсын шүүхийн тайлан, 2018 он. https://www.judcouncil.mn/site/news_full/8704

⁸ Монгол улсын шүүхийн тайлан., 2019 он https://www.judcouncil.mn/site/news_full/10084

⁹ Монгол улсын шүүхийн тайлан., 2020 он.

<https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view>

¹⁰ Монгол улсын шүүхийн 2021 оны эхний хагас жилийн шүүх таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ https://www.judcouncil.mn/site/news_full/11367

№	Өргөдөл, нэхэмжлэл шийдвэрлэлт	Өргөдөл гаргагч өргөдлөөсөө татгалзсан	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал хүлээн авахаас татгалзсан	Шийдвэрлэсэн
1	2018	1585	1092	12092
2	2019	1654	1717	12860
3	2020	2268	4135	14270
4	2021 оны хагас жил	1424	1376	5815

№	Шийдвэрлэсэн хэргийн задаргаа	Эвлэрүүлэн амжилттай		Эвлэрүүлэн амжилтгүй	
		тоо	Хувь	тоо	Хувь
1	2018	12092			
		8711	72,1%	3318	27,9%
2	2019	12860			
		9227	71,7%	3633	28,3%
3	2020	14270			
		10415	73%	3855	27%
4	2021 оны хагас жил	5815			
		4104	70,6%	1711	29,4%

Шийдвэрлэсэн иргэний хэрэгтэй харьцуулбал:

№	Он/ хэргийн тоо	Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо ¹¹	Эвлэрүүлэн зуучлалаар амжилттай шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо	Эзлэх хувь
1	2018	41363	8711	17,4%
2	2019	37387	9227	19,7%
3	2020	46389	10415	22,4%
4	2021 оны хагас жил	17601	5815	24,8%

Маргааны төрөл

№	Маргааны төрөл/ он	2018	2019	2020	2021 оны хагас жил
1	Иргэний эрх зүйн маргаан	9067 75%	9828 76,4%	11239 78,7%	4487 77,2%
2	Гэр бүлийн эрх зүйн маргаан	2995 24,8%	3020 23,5%	3015 21,2%	1270 21,8%
3	Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	30 0,2%	12 0,1%	16 0,1%	17 0,3%
4	Урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан	-	-	-	41

¹¹ Хэрэгсэхгүй болгосон хэргийг хассан дүнгээр

	өргөдөл нэхэмжлэл				0,7%
--	-------------------	--	--	--	------

Маргааны төрлөөр шийдвэрлэгдсэн байдал:

№	Он/ хэргийн тоо	Иргэний эрх зүйн маргаан		Гэр бүлийн эрх зүйн маргаан		Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан	
		Амжилт -тай	Амжилт -гүй	Амжилт- тай	Амжилт- гүй	Амжилт- тай	Амжилт -гүй
1	2018	8272 91,2%	795 8,8%	412 13,6%	2583 86,4%	27 90%	3 10%
2	2019	8840 89,9%	988 10,1%	377 12,5%	2643 87,5%	10 83,3%	2 16,7%
3	2020	10051 89,4%	1188 10,6%	353 11,7%	2662 88%	11 68,7%	5 31,3%
4	2021 оны хагас жил	3935 87,7%	552	137 10,8%	1133 89,2%	16 94,1%	1 5,9%

Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэгдсэн 2018 оны нийт 8711 хэргээс 2995 хэрэг гэр бүлийн эрх зүйн маргаан, 2019 оны нийт 9227 хэргээс 3020 хэрэг нь гэр бүлийн эрх зүйн маргаан, 2020 оны 10415 хэргээс 3015 хэрэг нь гэр бүлийн эрх зүйн маргаан байжээ. Гэр бүлийн эрх зүйн маргаан нь шийдвэрлэгдэж байгаа нийт хэрэг маргааны 25 хүрэхгүй хувийг эзэлж байна. Үүнээс эвлэрүүлэн зуучлал амжилттай, амжилтгүй болсон тоо мэдээллийг харвал Гэр бүлийн эрх зүйн маргааны амжилтгүй болсон тоон үзүүлэлт өндөр байна. Тухайлбал, 2018 онд нийт 2995 гэр бүлийн эрх зүйн маргааны 412 хэрэг эвлэрч, 2583 хэрэг эвлэрээгүй, 2019 онд нийт 3020 гэр бүлийн эрх зүйн маргааны 377 хэрэг эвлэрч, 2643 хэрэг эвлэрээгүй, 2020 онд 3015 гэр бүлийн эрх зүйн маргааны 353 хэрэг эвлэрч, 2662 хэрэг дээр эвлэрээгүй, 2021 оны хагас жилийн байдлаар 1270 гэр бүлийн эрх зүйн маргаанаас 137 хэрэг эвлэрч, 1133 хэрэг эвлэрээгүй байна. Хэдийгээр шүүх, болон эвлэрүүлэн зуучлагч нар гэрлэгч нарыг эвлэрүүлэх бүхий л арга хэмжээг авдаг ч гэрлэгчид тус тусдаа амьдралтай болсон, дуудсан цагт ирэхгүй эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцохгүй байх тохиолдол их байдаг талаар эвлэрүүлэн зуучлагч нар судалгааны явцад хэлж байсан.

Эвлэрүүлэн зуучлагч нар эхний ээлжид оролцогчдыг уулзуулах уулзалт товлон бөгөөд тухайн уулзалтдаа гэрлэгчдийг оролцуулж чаддаггүй байна. Учир нь эвлэрүүлэн зуучлагч шүүх шиг ажиллагаанд оролцогчдыг албадан авчрах боломжгүй байдаг. Тиймээс урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид нь уулзалтын тов мэдсэн ч ирэхгүй байх тохиолдол их байдаг байна. Үүнээс үүдэж гэрлэгчдийг эвлэрүүлэх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа амжилтгүй болох нь бий.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5-д “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах

ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, маргаан үүсгэгч талуудын байгуулсан гэрээнд “эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр заасан” бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д заасан үндэслэлд хамаарах буюу заавал урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх ёстой юм. Гэхдээ гэрээндээ заалт оруулснаас үүдэж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн хэрэг байхгүй байна. Гэрээндээ тусгаагүй ч талууд сайн дураараа эвлэрүүлэн зуучлагчид хандах боломжтой байдаг бөгөөд уг маргаан нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны Иргэний эрх зүйн маргаан гэсэн төрөлд багтаж тоо, мэдээлэл судалгаа нь нэгтгэгдэж гардаг аж. Уг маргаан шийдвэрлэсэн тоог урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн гэж үзэх боломжгүй. Учир нь урьдчилан шийдвэрлэх ажиллагаа бол заавал хийгдсэн байхыг шаарддаг зохицуулалттай.

3.5. Санхүүгийн зохицуулах хорооны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний зохицуулалт

Даатгалын тухай хуулийн 82.1-д “Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно” гэж заасан. Хөдөлмөрийн маргаантай харьцуулахад Даатгалын үйл ажиллагаатай холбогдох маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах субъект нь Санхүүгийн зохицуулах хороо гэж хуульд тодорхой заагдсан тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д зааснаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх боломжтой гэж үзэж энэ төрлийн маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа заавал хийгдсэн байхыг шаарддаг.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль /2005 он/ - ийн 6 дугаар зүйлд Хорооны бүрэн эрхийг заахдаа 6.1.6-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх” гэж, 7 дугаар зүйлийн 7.1-д “Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.” гэж, 8 дугаар зүйлийн 8.1-д “Хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд түүнд Хорооны дарга гарын үсэг зурна.”, 8.2-д “Бүрэн эрхийнхээ хүрээнд Хорооны гаргасан шийдвэр тогтоол хэлбэртэй байна.” гэж тус тус заасан байна. Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг **Зохицуулах хороонд** тавьж шийдвэрлүүлнэ гэж заасан байдаг тул уг хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хорооны хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байхаар байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиас өөр Даатгалын үйл ажиллагаанд холбогдон гарсан маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой нарийвчлан дүрэм, журам байдаггүй. Практикт Санхүүгийн зохицуулах хороо урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулаад гарсан шийдвэрээ гомдол гаргагч болон даатгалын байгууллагад албан бичгээр хүргүүлдэг байна. Ингэхдээ дараах 3 төрлийн шийдвэрийг гаргадаг. Үүнд:

1. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэж нөхөн төлбөр олгох талаар хугацаатай үүрэг өгсөн албан бичиг хүргүүлэх
2. Гомдол гаргагчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж үзэж, шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой талаар дурдсан албан бичиг хүргүүлэх
3. Шийдвэрлэх боломжгүй, шүүхээр шийдвэрлүүлэх талаар албан бичиг хүргүүлэх

Санхүүгийн зохицуулах хорооны гомдол шийдвэрлэсэн байдал:

Тоон мэдээллүүд:

Санхүүгийн зохицуулах хорооны хүлээн авч байгаа өргөдөл, гомдлын дийлэнх нь Даатгалын үйл ажиллагаанд холбогдох маргаан байдаг байна.

№	Он	Нийт хүлээн авсан өргөдөл гомдол	Даатгалын үйл ажиллагаатай холбогдох өргөдөл гомдол	
			Тоогоор	хувиар
1	2017 ¹²	267	154	52,8%
2	2018 ¹³	367	150	40,9%
3	2019 ¹⁴	346	186	53,7%

Өргөдөл гомдлыг даатгалын бүтээгдэхүүний төрлөөр ангилж үзвэл:

№	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	2017 он	2018 он	2019 он
1	Жолоочийн хариуцлагын даатгал	47	24	43
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	48	65	77
3	Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал	31	22	32
4	Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой бусад маргаан	2	8	3
5	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5	7	13
6	Хөрөнгийн даатгал	7	5	13
7	Хариуцлагын даатгал	6	4	4
8	Ачаа, тээврийн даатгал	-	4	1
9	Санхүүгийн даатгал	1	4	0
10	Мал амьтны даатгал	2	3	0
11	Зээлийн даатгал	3	1	0
12	Хуримтлалын даатгал	2	1	0
13	Эрүүл мэндийн даатгал	-	1	0
14	Агаарын хөлгийн даатгал	-	1	0

Даатгалын үйл ажиллагаанд холбогдох өргөдөл, гомдлын агуулга:

№	Өргөдөл, гомдлын товч утга	2017 он		2018 он		2019 он	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	101	65,5%	114	76%	127	68,3%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	10	6,5%	14	9,3%	11	5,9%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	24	15,6%	9	6%	23	12,4%
4	Бүтээгдэхүүн, үйлчилгээтэй	2	1,3%	8	5,4%	16	8,6%

¹² Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2017 оны өргөдлийн судалгаа

¹³ Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2018 оны өргөдлийн судалгаа

<http://www.frc.mn/resource/frc/Document/2020/01/22/xge6drpv4o2x1p6/2018%20%D0%BE%D0%BD%D1%8B%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0%204.pdf>

¹⁴ Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2019 оны өргөдлийн судалгаа

<http://www.frc.mn/resource/frc/Document/2020/06/23/x0kkqcg0va1lubn4/2019%20%D0%BE%D0%BD%D1%8B%20%D3%A9%D1%80%D0%B3%D3%A9%D0%B4%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0.pdf>

	холбоотой бусад маргаан						
5	Хохирол үнэлгээний талаар	7	4,5%	3	2%	5	2,7%
6	Даатгалын хураамжийг илүү тооцсон	10	6,5%	2	1,3%	4	2,1%

Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрч даатгалын байгууллагаас олгосон нөхөн төлбөрийн хэмжээ:

№	Он	Санхүүгийн зохицуулах хорооноос олго гэж шийдвэрлэсэн		Уг шийдвэрийг биелүүлж, даатгалын байгууллагаас	
		Иргэн, хуулийн этгээдийн тоо	нийт нөхөн төлбөрийн дүн /төгрөгөөр/	Иргэн, хуулийн этгээдийн тоо	олгосон нөхөн төлбөрийн дүн /төгрөгөөр/
1	2017 ¹⁵	-	295 425 859	-	43 126 006
2	2018	29	622 316 500	11	133 194 385
3	2019	73	710 541 823	24	212 564 554

Даатгалын үйл ажиллагаанд холбогдох маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь Санхүүгийн зохицуулах хорооны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 50-иас багагүй хувийг эзэлдэг байна. Тус судалгаанд гомдол гаргагчаас гаргасан өргөдөл гомдлыг Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн шийдвэрлэсэн талаарх тоон мэдээлэл байхгүй байгаа тул Санхүүгийн зохицуулах хорооны гомдлыг хангаж шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн мөнгөн дүнг биелүүлсэн мөнгөн дүнтэй харьцуулах замаар урьдчилан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрийн биелэлтийг тооцож үзлээ. Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн биелэлт 2017 онд 14.6% , 2018 онд 21.4% , 2019 онд 29.9% хувьтай байна.

Жич: Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох мэдээллийг гаргаж өгөхийг хүссэн албан бичиг хүргүүлсэн боловч цахим хуудаснаас мэдээлэл ав гэсэн хариу ирүүлж, нэмэлт мэдээлэл гаргаж өгөөгүй болохыг дурдаж байна.

Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа:

Монгол улсын шүүхийн шийдвэрийн www.shuukh.mn сайтад 2019 оны 01 сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 сар хүртэлх хугацаанд Даатгалын үйл ажиллагаатай холбогдох нийт 64 хэргийн шүүхийн шийдвэр тавигдсан байна. Үүнээс судалгааны чиглэлд хамаарах урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь 24 байна¹⁶. Тус шүүхийн шийдвэрүүдэд анализ хийж үзвэл:

¹⁵ Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2017 оны өргөдлийн судалгаанд бичигдээгүй.

¹⁶ Даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь даатгуулагчид нөхөн төлбөр олгосны дараа хуулиараа буруутай этгээдээс олгосон нөхөн төлбөрөө гаргуулах нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Тус эрхийнхээ дагуу нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлсэн шүүхийн шийдвэр нь Даатгалын маргаан гэсэн төрөлд хамаарч гарч ирж байгаа бөгөөд уг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь үнэлгээ хийх хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн зохицуулах хороо даатгалын үйл ажиллагаанд холбогдох маргааныг шийдвэрлэхдээ 3 төрлийн шийдвэрийг гаргаж, гомдол гаргагчид албан бичгээр хүргүүлж байна. Үүнд,

1. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэж нөхөн төлбөр олгох талаар хугацаатай үүрэг өгсөн албан бичиг хүргүүлэх
2. Гомдол гаргагчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж үзэж, шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой талаар дурдсан албан бичиг хүргүүлэх
3. Шийдвэрлэх боломжгүй, шүүхээр шийдвэрлүүлэх талаар албан бичиг хүргүүлэх

Шүүхийн шийдвэрийн цахим санд байгаа 24 шүүхийн шийдвэрийн 16 маргаанд Санхүүгийн зохицуулах хороо нөхөн төлбөр олгох нь үндэслэлтэй гэж үзэж, даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагад уг шийдвэрийг биелүүлэх хугацаа заасан мэдэгдлийг хүргүүлсэн байна. Тус шийдвэрийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь биелүүлээгүй байх бөгөөд уг шийдвэрийг эсэргүүцэж гомдол гаргаагүй, харин даатгуулагч иргэн, хуулийн этгээд Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг биелүүлэхгүй байгаа тул нэхэмжлэл гаргаж маргаан үүсгэсэн байна. Өөрөөр хэлбэл, Санхүүгийн зохицуулах хорооны маргаан шийдвэрлэж, хариу өгч байгаа тус хэлбэр нь 2 төрлийн зөрчилдөөн үүсгэжээ. Үүнд, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр нь тухайн маргааныг шийдвэрлэсэн эцсийн шийдвэр биш бөгөөд нөхөн төлбөр олгох нь үндэслэлтэй талаарх шийдвэр гаргасан байсан ч уг шийдвэрийг даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байх ёстой юм. Гэтэл хугацаатай үүрэг өгч, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг биелүүлж, хариу мэдэгд гэсэн албан бичиг хүргүүлж байгаа нь даатгалын байгууллагын уг шийдвэрт гомдол гаргах эрхийг зөрчих юм. Нөгөө талаас даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь уг мэдэгдлийг хүлээн авсан ч биелүүлэхгүй, маргахгүй байгаа нь тус урьдчилан шийдвэрлэх ажиллагааг үр дүнгүй, хэлбэрийн төдий буюу шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнөх цаг авсан ажил болгож байна. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг хэрхэн биелүүлэх талаарх зохицуулалт байхгүйгээс үүссэн гэж дүгнэгдэхээр байна.

Тохиолдол 1. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 сарын 16-ны өдрийн 181/ШШ2020/02568 дугаар шийдвэрт:

Гомдол гаргагч нь банктай зээлийн гэрээ байгуулахдаа зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байна. Даатгалын гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд гомдол гаргагч хорт хавдартай болох нь оношлогдож, хөдөлмөрийн чадвар алдалт нь 80 хувиар тогтоогдсон. Даатгагч байгууллагаас нөхөн төлбөр хүсэхэд олгоогүй байна. Харин Санхүүгийн зохицуулах хороо “даатгалын гэрээнд заасан эрсдэл үүссэн болох нь нотлох баримтын хүрээнд тогтоогдож байна гэсэн дүгнэлтийг гаргаж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалтыг баримтлан даатгалын гэрээнд заасан

эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгож 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд болон иргэнд мэдэгдэхийг үүрэг болгож” шийдвэрлэсэн байна. Гэтэл даатгалын байгууллага уг хугацаанд тус шийдвэрийг биелүүлээгүйн дээр, Санхүүгийн зохицуулах хорооны тус шийдвэрт гомдол гаргаагүй. Гомдол гаргагч даатгалын байгууллага Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг биелүүлээгүй учраас шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Тохиолдол 2. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 181/ШШ2020/02269 дугаар шийдвэрт:

Гомдол гаргагч нь Авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ байгуулсан байна. Даатгалын гэрээний хугацаанд автомашин цахилгаанаас үүдэлтэй гал гарч, даатгалын зүйл болох машин бүрэн шатсан байна. Даатгалын компанидаа хандахад нөхөн төлбөр олгохгүй гэсэн тул Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргажээ. Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 9/4249 дугаартай хариу албан бичигтээ “...Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт зааснаар мөн Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт заасан заалтуудыг тус тус үндэслэн даатгуулагчийн сонгосон багцын хувиар тооцож даатгалын нөхөн төлбөрийг олгох нь зүйтэй гэж үзлээ.” гээд энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор тус хороонд эргэж мэдэгдэхийг үүрэг болгосон байна. Гэтэл даатгагчид хандаж хяналт тавих эрх бүхий байгууллага нь үүрэг болгосоор байтал биелүүлээгүй тул гомдол гаргагч шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Харин даатгагч байгууллагын төлөөлөгч шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа “Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн тухайд Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компани болоод даатгуулагчийн хооронд гарсан маргааныг хороо урьдчилан шийдвэрлэнэ. Талууд энэ шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно гэсэн зохицуулалтын хүрээнд урьдчилан шийдвэрлэсэн буюу уг шийдвэр нь эцсийн шийдвэр биш юм гэдгийг дурдах нь зүйтэй байх.” гэж хэлсэн байна. Өөрөөр хэлбэл, даатгагч байгууллага хуулийн заалтын агуулгыг бүрэн дүүрэн ойлгож байгаа ч Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрт гомдол гаргахгүй, биелүүлэхгүй нөхөн төлбөр олгох хугацааг хойшлуулах арга хэрэгсэл болгож байна.

Шүүхийн шийдвэрийн цахим санд байгаа 24 шүүхийн шийдвэрийн 4 маргаанд Санхүүгийн зохицуулах хороо нөхөн төлбөр олгохгүй гэсэн даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж, гомдлыг хангахаас татгалзсан байх бөгөөд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой талаарх дурдаж өгсөн байна. Тус шийдвэрийг гомдол гаргаж хүлээн зөвшөөрөлгүй, шүүхэд нэхэмжлэл гаргаж, Шүүхээс 3 маргааныг Санхүүгийн зохицуулах хороотой адил шийдвэрлэсэн бол 1 маргаанд нэхэмжлэлийг шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэжээ.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны нөхөн төлбөр олгохгүй гэсэн

шийдвэрийг авсан гомдол гаргагч бүр шүүхэд нэхэмжлэл гаргадаггүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр хүчин төгөлдөр үйлчлэх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны урьдчилан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явагдсан гэж үзэх боломжтой бөгөөд энэ хэмжээгээр иргэний шүүхийн ачаалал багасна.

Тохиолдол 3. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 сарын 18-ны өдрийн 181/ШШ2020/01314 дугаар шийдвэрт:

Гомдол гаргагч Ипотекийн зээлдэгчийн төлбөр тасалдлын даатгалын гэрээ байгуулсан байна. Тус гэрээний хугацаанд даатгуулагч нойр булчирхайн хорт хавдар оношоор нас баржээ. Даатгуулагчийн эхнэр даатгалын тохиолдол үүссэн гэж үзэж нөхөн төлбөр гаргуулах хүсэлт даатгагчид гаргасан ч “даатгалын тохиолдол биш” гэж үзсэн байна. Хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргасан. Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны 4 дүгээр сарын 12-ний өдрийн 9/1944 албан тоотоор “даатгуулагч Б.Цолмонхүүгийн нас барсан шалтгааныг Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчийн онош, дүгнэлтээр нойр булчирхайн хорт хавдрын улмаас гэж тогтоосон байх бөгөөд энэ нь талуудын хооронд байгуулсан Ипотекийн зээлдэгчийн төлбөр тасалдлын даатгалын 1201281027930 тоот гэрээний 3.2-т “Зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалын дараах тохиолдлуудын шууд ба шууд бус үр дагаврын улмаас учирсан хохирол нөхөн төлбөр олгохгүй” хэсгийн 3.2.15-д “Архаг болон хууч өвчнөөс үүдэлтэй нас баралт,…” гэж заасны дагуу даатгагч нь даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй байна” гэсэн хариу өгсөн. Гомдол гаргагч Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрч, шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Шүүхээс маргааныг шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаагүй байна.

Тохиолдол 4. Иргэн даатгалын компанитай тээврийн хэрэгсэл даатгуулах гэрээ хийхдээ экономик+хамгаалалтын нөхцөлийг сонгон даатгуулсан байна. Уг тээврийн хэрэгслийг даатгуулагчийн төрөл садангийн хүн унаж яваад / жолоо шилжүүлэх үеийн эрсдэл/ осолд орсон бөгөөд даатгуулагчийн зүгээс даатгалын компанид хандан нөхөн төлбөр хүссэн ч нөхөн төлбөр олгохоос татгалзсан байдаг. Хуульд заасны дагуу даатгуулагч Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргасан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос хариу хүргүүлэхдээ “...даатгуулагч даатгалын гэрээнд экономик+ хамгаалалтын нөхцөлийг сонгон даатгуулсан байх ба уг хамгаалалтад жолоо шилжүүлэх үеийн эрсдэл хамаарахгүй, мөн даатгалын зүйлийг жолоодон явсан жолооч нь таны төрөл садангийн хүн болох нь талуудын ирүүлсэн баримтаар тогтоогдохгүй байгаа тул даатгагчийн нөхөн төлбөр олгохоос татгалзсан шийдвэр үндэслэлтэй байна. Та даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу даатгалын гэрээ болон нөхөн төлбөртэй холбоотой маргааныг иргэний журмаар шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой” гэсэн хариуг хүргүүлсэн байна. Даатгуулагчийн зүгээс шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр хүчин төгөлдөр болжээ.

Харин цахим санд байрласан 4 маргаанд Санхүүгийн зохицуулах хороо урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх боломжгүй гэж үзэж, шууд шүүхэд хандахыг зөвлөсөн байна.

Тохиолдол 5. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 сарын 28-ны өдрийн 01253 дугаар шийдвэрт:

Гомдол гаргагч нь Авто тээврийн хэрэгслийн даатгалын баталгааны гэрээ байгуулж, автомашины стандарт нөхцөлөөр даатгуулсан байна. Гэрээний хугацаанд даатгуулагч машин нь асахгүй байсан учир галын цог тавьж гэсгээх гэж байгаад санамсаргүй гал алдаж, машин бүрэн шатсан байна. Даатгагчийн зүгээс санаатай эд хөрөнгө шатаасан гэж үзэж нөхөн төлбөр олгохоос татгалзсан. Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргахад “шийдвэрлэх боломжгүй” гэсэн тодорхойгүй хариу өгч шүүхэд хандахыг зөвлөжээ. Иймд гомдол гаргагч шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Дэлгэрэнгүйг хавсралт №2 үзэх боломжтой.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

1. Хөдөлмөрийн тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт практикт бодитоор хэрэгжихгүй явсаар өдийг хүрсэн байна.
2. Тус хуулийн зохицуулалтыг үнэлэхэд холбогдох дүрэм журам нь батлагдсан хэдий ч түүнийг хэрэгжүүлэх субъект нь байхгүй, түүнд хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгөх субъект байхгүй, хөдөлмөрийн маргаан таслах комисс байгаад гаргасан шийдвэрийг албадан биелүүлэх хуулийн зохицуулалт байхгүй дутагдаж байсан тул бодит байдалд хэрэгждэггүй, шинэчлэх шаардлага хэдийн бий болсон байжээ.
3. Харин 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн хуулийн урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан зүйл, заалтуудыг илүү нарийвчлан, дээрх дутагдлуудыг арилгаж, хэрэгжих боломжтой олон шинэлэг зохицуулалтыг тусгасан байна. Тус хууль нь 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
4. Гэр бүлийн тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дагуу Гэрлэлт цуцлахтай холбоотой маргаанд эвлэрүүлэн зуучлагч нар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийдэг хэдий ч маргаан үүсгэсэн талуудын 11-13 хувь эвлэрч, 87-89 хувьд ажиллагаа амжилтгүй болдог байна.
5. Гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан нь Гэр бүлийн тухай хуульд зааснаар заавал хийгдэх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хэдий ч урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулах журам нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар тодорхойлогддог тул маргааны талуудыг албадах боломжгүй байдаг.
6. Гэрлэлт цуцлалтыг шийдвэрлэж байгаа урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дийлэнх нь Эвлэрүүлэн зуучлагчийн дуудсан цагт ирэхгүй байх, уулзалт зохион байгуулж чадаагүй зэрэг байдалтай холбоотой байна.
7. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Даатгалын үйл ажиллагаанд холбогдох маргааныг Санхүүгийн зохицуулах хороо нь хуралдаанаар шийдвэрлэж, тогтоол гаргахаар байгаа боловч практикт шийдвэр нь албан бичгээр иргэн, хуулийн этгээдэд хүрч байна.
8. Даатгалын тухай хуульд заасан ерөнхий зохицуулалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо гомдлыг хянан шийдвэрлэж, талуудад албан бичгээр хүргүүлдэг ч Даатгалын байгууллага уг шийдвэрт гомдол гаргахгүй атлаа биелүүлэхгүй байх тохиолдол их байна.

9. Гомдол гаргагч Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр өөрийнх нь талд гарсан ч, шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломжгүй байгаагаас үүдэлтэй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ, САНАЛ

1. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хууль дахь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт, түүний хэрэгжилт хангалтгүй, уг хуулийн заалтуудыг шинэчлэх найруулах шаардлагатай байсан. Гэвч 2021 оны 01 сарын 01-нд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээрх зохицуулалтыг илүү боловсронгуй болгож тусгасан байх тул нэмж гаргах зөвлөмж, саналгүй болно.
2. Гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан нь Гэр бүлийн тухай хуульд зааснаар заавал хийгдэх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хэдий ч урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах журам нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар тодорхойлогддог тул маргаанд талуудыг албадах боломжгүй байгаа нь уг ажиллагаа үр дүнгүй болох нэг нөхцөл болж байгаа тул тус эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гэрлэгчдийг заавал оролцуулах зохицуулалтыг хуульд тусгах
3. Санхүүгийн зохицуулах хорооны хүчин төгөлдөр болсон шийдвэрийг шүүгчийн захирамжаар албажуулах, улмаар албадан гүйцэтгүүлэх боломжтой хуулийн зохицуулалтыг тусгах

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийг бодитой, үр дүнтэй болгохын тулд Гэр бүлийн тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
2. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
3. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
4. Даатгалын тухай хууль, 2004 он
5. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2012 он
6. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он
7. “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”, Засгийн газрын 1999 оны 122-р тогтоолын 2-р хавсралт

Судалгааны мэдээ, судалгааны тайлан, ном

1. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn/-гийн Даатгалын маргаанд холбогдох шийдвэрүүд /2019.01.01-ний өдрөөс 2021.08.23-ний өдрийн байдлаар/
2. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn/-гийн Хөдөлмөрийн маргаанд холбогдох шийдвэрүүд /2019.01.01-ний өдрөөс 2021.08.23-ний өдрийн байдлаар/
3. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгосон тэмдэглэл” /2019, 2020, 2021 оны/
4. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамж /2019, 2020, 2021 оны/
5. Монгол улсын шүүхийн 2018 оны тайлан
6. Монгол улсын шүүхийн 2019 оны тайлан
7. Монгол улсын шүүхийн 2020 оны тайлан
8. Монгол улсын шүүхийн 2021 оны хагас жилийн тайлан
9. Санхүүгийн зохицуулах хороо- 2017 оны өргөдлийн судалгаа
10. Санхүүгийн зохицуулах хороо- 2018 оны өргөдлийн судалгаа
11. Санхүүгийн зохицуулах хороо- 2019 оны өргөдлийн судалгаа

Цахим эх сурвалж

1. <http://opendata.burtgel.gov.mn>
2. <http://www.frc.mn>
3. <https://www.judcouncil.mn/>
4. www.shuukh.mn

ХАВСРАЛТ

Хавсралт №1

1999 он болон 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан зүйл, заалтын харьцуулалт

Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/	Хөдөлмөрийн тухай хууль /2021 он/
125 дугаар зүйл.Хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хянан шийдвэрлэх 125.1.Ажил олгогч, ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс, шүүх тус тусын харьяаллын дагуу шийдвэрлэнэ.	54 дүгээр зүйл.Хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах 154.2.Хөдөлмөрийн эрхийн маргааныг маргалдагч тал эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш дараах хугацаанд хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисст, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссгүй аж ахуйн нэгж, байгууллага болон иргэд хооронд үүссэн маргааныг сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд тус тус хандах эрхтэй: 154.2.1.хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан буюу дуусгавар болгосон, эсхүл өөр ажилд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан тухай ажил олгогчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор; 154.2.2.энэ хуулийн 154.2.1-д зааснаас бусад хөдөлмөрийн эрхийн маргаантай асуудлыг 90 хоногийн дотор. 154.3.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор талуудыг оролцуулан шийдвэрлэнэ. 154.4.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны урьдчилан шийдвэрлэх явцад талууд маргаантай асуудлаар харилцан тохиролцсон бол энэ тухай тэмдэглэл үйлдэж маргалдагч талууд гарын үсэг зурснаар хөдөлмөрийн
126 дугаар зүйл.Хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэх маргаан 126.1.Шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад маргааныг хөдөлмөрийн маргаан таслах комисс анх дутам хянан шийдвэрлэнэ. 126.2.Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмийг Засгийн газар батална.	
127 дугаар зүйл.Хөдөлмөрийн маргаан таслах	

комиссын шийдвэрийг давж заалдах 127.1.Ажил олгогч буюу ажилтан нь хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл, түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих сум, дүүргийн шүүхэд давж заалдах эрхтэй. 128 дугаар зүйл.Шүүхээр хянан шийдвэрлэх маргаан 128.1.Дараахь маргааныг шүүхээр хянан шийдвэрлэнэ: 128.1.1.Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг энэ хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу давж заалдсан гомдол; 128.1.2.ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдол; 128.1.3.ажилтнаас хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байхдаа аж ахуйн нэгж, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл; 128.1.4.хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үед эрүүл мэнд нь хохирсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажилтны	эрхийн маргаан шийдвэрлэгдсэнд тооцно. 154.5.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх журмаар зохицуулж чадаагүй бол энэ талаар тэмдэглэл үйлдэж талууд гарын үсэг зурснаар маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ дуусгавар болно. 154.6.Энэ хуулийн 154.5-д заасан хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын тэмдэглэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч аль нэг тал хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд хандана. 154.7.Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо энэ хуулийн 154.6-д заасны дагуу гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргааныг хянаж, шийдвэр гаргана. 154.8.Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны энэ хуулийн 154.5-д заасан тэмдэглэлийг хүлээн авснаас хойш, эсхүл энэ хуулийн 154.7-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч тал шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. 154.9.Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо хөдөлмөрийн эрхийн маргааныг хянан шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор талууд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол уг шийдвэрийг талууд заавал биелүүлэх үүрэгтэй.
--	---

нэхэмжлэл; 128.1.5.энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан асуудлаар гарсан маргаан; 128.1.6.иргэн хоорондын хөдөлмөрийн гэрээтэй холбогдон гарсан маргаан; 128.1.7.сахилгын шийтгэл буруу ногдуулсан тухай ажилтны гомдол; 128.1.8.хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хууль тогтоомж болон хамтын гэрээнд зааснаас дордуулсан тухай ажилтны нэхэмжлэл; 128.1.9.хөдөлмөрийн дотоод журам хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар өөрийн онцлогт тохируулан тогтоосон байгууллагын бусад тушаал, шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй тухай ажилтны нэхэмжлэл; <i>/Энэ заалтад 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i> 128.1.10.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчдын хоорондын хөдөлмөрийн маргаан; 128.1.11.хууль тогтоомжоор шүүхэд харьяалуулсан бусад маргаан.	154.10.Хамтын гэрээ, салбар, салбар дундын болон улсын хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөдөлмөрийн эрхийн маргааныг энэ хуульд заасан хөдөлмөрийн сонирхлын маргаан зохицуулах журмаар шийдвэрлэнэ. 154.11.Энэ зүйлд заасны дагуу хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, эсхүл сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор урьдчилан шийдвэрлэсэн тэмдэглэлийг, эсхүл шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш маргалдагч аль нэг тал ажлын таван өдөрт багтаан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болно. 156 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс 156.1.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулна. 156.2.Энэ хуулийн 154.1-д заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг шийдвэрлэхээр 20-оос доош ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага байнгын бус комисс байгуулж болно. 156.3.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс нь ажил олгогч болон аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрчний эвлэл, хэрэв ийм байгууллага байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон ажилтны тэнцүү тооны төлөөллөөс бүрдэнэ. 156.4.Энэ хуулийн 156.3-т заасан төлөөлөгч нь аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны бүрэлдэхүүнд хамаарах албан тушаалтан байхыг хориглоно. 156.5.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс талуудын хооронд үүссэн хөдөлмөрийн эрхийн маргааныг шийдвэрлэхэд
---	--

129 дүгээр зүйл.Маргааны талаар гомдол гаргах хугацаа 129.1.Хөдөлмөрийн гэрээний талууд энэ хуулийн 129.2-т зааснаас бусад тохиолдолд эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш гурван сарын дотор хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллагад гомдлоо гаргах эрхтэй.	боломжтой бүх арга хэмжээг авах үүрэгтэй. 156.6.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрмийг Засгийн газар батална. 158 дугаар зүйл.Хөдөлмөрийн эрхийн маргааныг шүүхээр шийдвэрлэх 158.1.Дараах хөдөлмөрийн эрхийн маргааныг шүүх шууд хянан шийдвэрлэнэ: 158.1.1.энэ хуулийн 154.8-д заасны дагуу гаргасан гомдол; 158.1.2.энэ хуулийн 129.2, 130.1-д зааснаас бусад ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл; 158.1.3.хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн тухай ажилтны гомдол; 158.1.4.энэ хуулийн 154.4, 154.9-д заасан шийдвэрийг биелүүлээгүй талаарх гомдол; 158.1.5.хууль тогтоомжид заасан бусад маргаан. 158.2.Дараах тохиолдолд ажилтан энэ хуулийн 154.2-т заасан хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагад хөдөлмөрийн маргаан шийдвэрлүүлэх боломжгүй гэж үзвэл шүүхэд хандаж хөдөлмөрийн эрхийн маргааныг шийдвэрлүүлнэ: 158.2.1.ажил үүргээ гүйцэтгэх явцад ажилтны амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргасан; 158.2.2.хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан буюу дуусгавар болгосон, эсхүл өөр ажилд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан тухай
---	---

	ажил олгогчийн шийдвэрийг үндэслэлгүй талаар ажилтан гомдол гаргасан. 158.3.Хөдөлмөрийн эрхийн маргааныг шүүхийн өмнөх шатанд шүүхийн эвлэрүүлэн зуучлалын журмаар урьдчилан шийдвэрлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.
--	--

**Даатгалын үйл ажиллагаанд холбогдох
маргааныг шийдвэрлэсэн байдал**

Монгол улсын шүүхийн шийдвэрийн www.shuukh.mn сайтад 2019 оны 01 сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 сар хүртэлх хугацаанд Даатгалийн үйл ажиллагаатай холбогдох нийт 64 хэргийн шүүхийн шийдвэр тавигдсан байна. Үүнээс судалгааны чиглэлд хамаарах урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь 24 байна¹⁷.

№	Шүүхийн шийдвэрийн мэдээлэл	Нэхэмжлэлийн шаардлага	Хариуцагчийн хариу тайлбар	Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа/ Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр
1.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.10.16 Дугаар: 181/ШШ2020/0256 8 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	Зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалын гэрээний дагуу 5,223,685 төгрөгийг гаргуулах	Нэхэмжлэлийн шаардлагын бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын гэрээнд заасан эрсдэл үүссэн болох нь нотлох баримтын хүрээнд тогтоогдож байна гэсэн дүгнэлтийг гаргаж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалтыг баримтлан даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатуулагчид

¹⁷ Даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь даатгуулагчид нөхөн төлбөр олгосны дараа хуулиараа буруутай этгээдээс олгосон нөхөн төлбөрөө гаргуулах нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Тус эрхийнхээ дагуу нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлсэн шүүхийн шийдвэр нь Даатгалын маргаан гэсэн төрөлд хамаарч гарч ирч байгаа бөгөөд уг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь үнэлгээ хийх хүрээнд хамаарахгүй болно.

				учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгож 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд болон иргэнд мэдэгдэхийг үүрэг болгосон.
2.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.09.09 Дугаар:181/ШШ20 20/02269 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	Авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөрт 5 000 000 төгрөг гаргуулах	Нэхэмжлэлийн шаардлагын бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 9/4249 дугаартай хариуг ирүүлсэн. Уг албан бичигт "...Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт зааснаар мөн Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт заасан заалтуудыг тус тус үндэслэн даатгуулагчийн сонгосон багцийн хувиар тооцож даатгалын нөхөн төлбөрийг олгох нь зүйтэй гэж үзлээ. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор тус хороонд эргэж мэдэгдэхийг үүрэг болгосон.
3.	Шүүх: СБДИХАШШ	Зээлдэгчийн гэнэтийн ослын	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь	Санхүүгийн зохицуулах хороо даатгуулагчид

	Огноо: 2020.05.27 Дугаар: 181/ШШ2020/0144 6 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагаас 36,844,900 /гучин зургаан сая найман зуун дөчин дөрвөн мянга есөн зуу/ төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Б.Ад олгон, нэхэмжлэлээс үлдэх 8,680,100 /найман сая зурган зуун наян мянга нэг зуу/ төгрөгийг хэрэгсэхгүй болгосон.	даатгалын гэрээний дагуу үндсэн зээлийн гэрээний 60,700,000 төгрөгийн 50 хувь болох 30,350,000 төгрөг, гэрээний алданги болох 15,175,000 төгрөг, нийт 45,525,000 төгрөг гаргуулах	хүлээн зөвшөөрөөгүй	даатгалын нөхөн олговор олгож, гүйцэтгэлийг ирүүлэх тухай 2018 оны 8 сарын 30-ны өдөр 9/3517 тоот хариу албан бичиг хэрэгт авагдсан.
4.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.05.18 Дугаар:181/ШШ2020/01314 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	“Ипотекийн зээлдэгчийн төлбөр тасалдлын даатгалын гэрээ”-ний дагуу даатгалын нөхөн төлбөрт 23,934,632 төгрөг гаргуулах.	нэхэмжлэлийг шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй	Санхүүгийн зохицуулах хороо Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар урьдчилан шийдвэрлэж 2018 оны 4 дүгээр сарын 12-ний өдрийн 9/1944 албан тоотоор “даатгуулагч Б.Цолмонхүүгийн нас барсан шалтгааныг Увс

				аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчийн онош, дүгнэлтээр нойр булчирхайн хорт хавдрын улмаас гэж тогтоосон байх бөгөөд энэ нь талуудын хооронд байгуулсан Ипотекийн зээлдэгчийн төлбөр тасалдлын даатгалын 1201281027930 тоот гэрээний 3.2-т “Зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалын дараах тохиолдлуудын шууд ба шууд бус үр дагаврын улмаас учирсан хохирол нөхөн төлбөр олгохгүй” хэсгийн 3.2.15-д “Архаг болон хууч өвчнөөс үүдэлтэй нас баралт,..” гэж заасны дагуу даатгагч нь даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй байна” гэсэн хариу өгсөн.
5.	Шүүх: ЧДИХАШШ Огноо: 2020.05.13 Дугаар:182/ШШ2020/01086	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний	нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй	Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 9/4331 дугаартай албан

	Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	дагуу даатгалын нөхөн төлбөрт 5.000.000 төгрөг гаргуулах тухай		бичигт “СД ХХК-ийн шийдвэр нь үндэслэлгүй болохыг хэд хэдэн хуулийн заалтаар тайлбарлан дүгнэлт гарган тус иргэний нөхөн олговрыг олгохыг шаардсан боловч хүлээж аван шийдэж өгөөгүй тул нөхөн олговор болох 5.000.000 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэв.
6.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.05.1 Дугаар:181/ШШ20/01155 Товч агуулга: “М” ХХК-д холбогдуулан гаргасан 4,227,694.96 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэгч Г.Хын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Амь даатгалын гэрээний дагуу үлдэгдэл 30,421,599 төгрөгийг нэхэмжилсэн	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй	Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын тохиолдол бий болсон байна. Тийм учраас даатгуулагчид нөхөн төлбөр гаргаж өгөх гэсэн шийдвэр гарсан.
7.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.03.09 Дугаар:181/ШШ20/00638 Товч агуулга:	Авто тээврийн хэрэгслийн 14С1990454 7 дугаартай гэрээний дагуу даатгалын нөхөн	нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй	Санхүүгийн зохицуулах хороо гомдлыг шалгаж үзээд 2019 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн №9/3459 тоот албан бичгээр “...талуудаас ирүүлсэн

	“СС” ХХК-аас даатгалын нөхөн төлбөрт 21,005,000 төгрөгийг гаргуулж Д.Д, Б.Б нарт олгох тухай буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	төлбөрт 21,005,000 төгрөг гаргуулах тухай	болгож өгөхийг хүссэн	баримтуудыг нягталж үзэхэд даатгуулагч Д.Д нь даатгалын гэрээний 15.11.18 дахь хэсгийг зөрчсөн гэдгийг даатгагчийн зүгээс үндэслэлгүйгээр тогтоосон гэж үзэхээр байна. Иймд даатгалын гэрээний нөхцөлийн дагуу даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгох нь зүйтэй” гэх хариуг өгсөн.
8.	Шүүх: ЧДИХАШШ Огноо: 2020.02.13 Дугаар:182/ШШ20 20/00373 Товч агуулга: Хариуцагч СД ХХК-иас 63,152,700 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Л.М д олгохоор шийдвэрлэсэн буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	Л.М нь СД ХХК-тай 2018.11.15-ны өдөр дотоод ачаа тээврийн даатгалын гэрээ байгуулсны дагуу Даатгалын нөхөн төлбөрт 63,152,700 төгрөг гаргуулах тухай	Нэхэмжлэгч Л.М эрхгүй үедээ шатахуун тээвэрлэж яваад зам тээврийн осол гаргаж, шатахуун асгарсан явдалд өөрөө буруутай гэж үзэж байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хороо өргөдлийг хянан шийдвэрлээд 2019.10.21-ний өдрийн 9/3685 дугаартай албан бичгээр Дотоод ачаа тээврийн даатгалын гэрээний зүйл нь 45.890 литр шатахуун бөгөөд тус шатахуунд даатгалын гэрээнд заасан эрсдлийн улмаас даатгалын тохиолдол бий болж хохирол учирсан бол даатгагч буюу СД ХХК нөхөн төлбөр олгохоор үүрэг хүлээсэн тул даатгалын нөхөн төлбөрийг олгохыг

				СД ХХК-нд мэдэгдсэн байна.
9.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.02.11 Дугаар:181/ШШ20 20/00439 Товч агуулга: МХК-иас 6.900.000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэгч С.Бийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Тээврийн хэрэгслийн даатгалын №190200733 0006 дугаар бүхий гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 6.900.000 төгрөг гаргуулах тухай.	Хохирлыг нотлох бололцоогүй, хангалттай нотлох баримт бүрдээгүй тул нэхэмжлэгч С.Бийн машинаа засуулах сэлбэг авах 5,850,000 төгрөг, Ашид билгүүн үнэлгээний газраар үнэлгээ хийлгэсэн 505,000 төгрөг, хэт их явдал чирэгдэл учруулж зардал гарсан 500,000 төгрөг нийт 6,900,000 төгрөг нэхэмжилсэн нэхэмжлэлийг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг чирэгдэлгүйгээр даруй шийдвэрлэ... гэсэн хариуг 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 9/3678 дугаартай албан бичгээр гаргасан.
10	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2020.01.24 Дугаар:181/ШШ20 20/00278 Товч агуулга: ХК-иас 5.000.000 \таван сая\	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний дагуу АХК-ийн 02/19/884 тоот нөхөн төлбөрийн	Зам дээр гараагүй буюу зам тээврийн осол болоогүй нь үйл баримтаар илэрхий байх тул жолоочийн даатгалын тохиолдол гэж үзэх боломжгүй	Санхүүгийн Зохицуулах Хорооны Даатгалын нөхөн төлбөрийн тухай 9/3680 тоот албан бичигт Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-

	төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Н.Бд олгохоор шийдвэрлэсэн буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	шийдвэрийг хүчингүй болгуулж, 5.000.000 төгрөг гаргуулах тухай	байна. Иймд Даатгалын тухай хуулийн 8.5.3-т даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан үндэслэлээр даатгалын нөхөн төлбөрийг олгох боломжгүй тул нэхэмжлэлийг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	д заасныг үндэслэн даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрийг тогтоосон хэмжээгээр олгож, уг шийдвэрийн биелэлтийг тус Хороонд 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг үүгээр мэдэгдье гэсэн
11	Шүүх: ХУДИХАШШ Огноо: 2019.11.21 Дугаар:181/ШШ201 9/02378 Товч агуулга: М Д ХК-иас даатгалын нөхөн төлбөрт 2,650,000 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Д.Н д олгохоор шийдвэрлэсэн буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу даатгалын гэрээний нөхөн төлбөрт 2,650,000 төгрөгийг гаргуулах тухай.	Монгол улсын Даатгалын тухай хуулийн 8.5.3-д “Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан гэх заалтуудыг үндэслэн нөхөн төлбөр олгохоос татгалзаж болно” гэж заасныг үндэслэн нөхөн төлбөр олгохоос татгалзсан тул нэхэмжлэлийг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 9/2196 дугаартай албан бичигт “...даатгалын нөхөн төлбөрийг тогтоосон хэмжээгээр олгож, 2019 оны 5 дугаар сарын 29-ний дотор тус Хороонд эргэж мэдэгдэхийг үүгээр үүрэг болгож байна”
12	Шүүх: ЧДИХАШШ	Гадаадад	Хариуцагч ХХК	Санхүүгийн

	Огноо: 2019.11.20 Дугаар: 182/ШШ2019/0203 8 Товч агуулга: Хариуцагч ХХК-иас даатгалын нөхөн төлбөрт 31,245,639.04 /гучин нэгэн сая хоёр зуун дөчин таван мянга зургаан зуун гучин есөн төгрөг, дөрвөн мөнгө/ төгрөг гаргуулж нэхэмжлэгч Б.Бад олгохоор шийдвэрлэсэн.	зорчигчийн иж бүрэн даатгалын дагуу даатгалын нөхөн төлбөрт 31,245,639.04 төгрөг гаргуулах тухай	нь “даатгалын гэрээний даатгалд хамрагдахгүй нөхцөлийн 2.b.Даатгуулах аас өмнө аливаа архаг хууч өвчин эмгэг, урьд нь өвдөж байсан өвчин” гэж заасан нөхцөлд хамаарч байгаа тул нөхөн төлбөр олгох үндэслэлгүй” хэмээн нэхэмжлэлийн шаадлагыг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	зохицуулах хороо 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 9/2154 тоот албан бичгээр “...даатгуулагчийн зүгээс даатгалын гэрээний дээрх заалтад заасны дагуу нөхөн олговрын маягтыг эмчилгээний тайлан эмчийн дүгнэлт эмнэлгийн төлбөрийн баримтын хамт бүрдүүлсэн байх ба ...даатгалын нөхөн төлбөрийг тогтоосон хэмжээгээр олгож 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дотор тус хороонд эргэж мэдэгдэхийг үүрэг болгосон байна”
13	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.10.16 Дугаар:02066 Товч агуулга: Хариуцагч “А” ХК-иас даатгалын нөхөн төлбөрт 46 516 827/дөчин зургаан сая таван зуун арван зургаан мянга найман зуун хорин долоо/	Амь насны даатгал дагуу 46 516 827 төгрөгийг гаргуулах тухай.	Хариуцагч “А” ХК нь Даатгалын гэрээний 8.1.8-д “Өвчин эмгэгийн улмаас нас барах” тохиолдол нь гэрээнд заасан эрсдэлд хамаарахгүй хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь	Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн № 9/2697 албан бичигт “А”-д нөхөн төлбөрийг олгохоор үүрэг болгосон.

	төгрөгийг гаргуулах нэхэмжлэгч Б.Уянгын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.		зөвшөөрөөгүй.	
14.	Шүүх: ЧДИХАШШ Огноо: 2019.09.25 Дугаар: 182/ШШ20 19/01649 Товч агуулга: Хариуцагч П ХХК-иас даатгалын нөхөн төлбөрт 9,153,102 төгрөг, алданги 1,556,027 төгрөг нийт 10,709,129 төгрөг гаргуулах нэхэмжлэгч Г.Эгийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	Зээлдэгчийн эрсдэлийн даатгалын 40514002391 тоот гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 3,868,633 төгрөг гаргуулах тухай	Хариуцагч П ХХК нь даатгалын гэрээ байгуулахаас өмнө эрсдэл бий болсон талаар мэдээлэх үүргээ биелүүлээгүй, даатгалын зуучлагч болох Хаан банк журам зөрчиж байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр бус хэлцэл тул нөхөн төлбөр олгохгүй хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 9/1951 тоот албан бичгээр "...Даатгалын зуучлагч Хаан банк ХХК-иар дамжуулан танай компанитай Орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгалын гэрээг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан нь эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан байна. Даатгагч болон даатгалын зуучлагч хоорондын хамтын ажиллагаа холбогдох гэрээний дагуу зохицуулагдах бөгөөд энэхүү гэрээг зөрчсөн, эсхүл гэрээний гүйцэтгэлийг шалгаж нягтлах үүргээ хэрэгжүүлээгүй мэргэжлийн байгууллагын албан тушаалтны буруутай буюу хариуцлагагүй

				үйл ажиллагаанаас болж даатгуулагчийн эрх ашиг зөрчигдэх учиргүй. Тиймээс даатгалын нөхөн төлбөрийг олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн
15.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.09.06 Дугаар: 01768 Товч агуулга: Хариуцагч “Х” ХХК-иас нийт 11 000 000/арван нэгэн сая/ төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Ж.Эд олгохоор шийдвэрлэсэн.	Тээврийн хэрэгсэлийн даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 11 000 000 төгрөгийг гаргуулах тухай.	Хариуцагч “Х” ХХК нь тээврийн хэрэгслийг жолоодон явсан этгээд баталгаат бус замаар зорчин даатгалын тохиолдол бий болгох нөхцөл орчныг бүрдүүлсэн гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 5 сарын 01-ний 9/1878 дугаартай албан бичигт “Онцгой байдлын галын байцаагчийн акт, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актууд зөрөөтэй учир шүүхэд асуудлаа шийдүүлэхийг мэдэгдсэн.
16.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.09.2 Дугаар: 182/ШШ2019/0146 4 Товч агуулга: “П.Д” ХХК-иас 22 265 871 төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэгч Д.Ч-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохоор	Орон сууц зээлдэгчийн амь насны даатгалын баталгааны гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 22 265 871 төгрөг гаргуулах тухай.	Талийгаач Ө.Чулуун-Эрдэнэ өвчний улмаас нас барсан явдал нь түүнийг гэнэтийн ослын улмаас нас барсан гэж үзэх үндэслэл болохгүй юм. Хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 дүгээр сарын 22-ны өдрийн 9/1258 дугаар албан бичгээр даатгалын мэргэжлийн үйл ажиллагааны оролцогчид тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн журмын 6.1.11-д зааснаас өөр нөхцөлтэй гэрээ байгуулж болохгүй талаар тодорхой тусгасан. Гэтэл одоо

	шийдвэрлэсэн.			хариуцагч тал ямар гэрээ бүртгүүлсэн, одоо ямар гэрээ байгуулсан талаар тодорхой мэдээлэл өгөхгүй байна. Үүнээс дүгнэхэд Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.1., Даатгалын тухай хуульд заасан даатгалын тохиолдол үүссэн учраас даатгалын нөхөн төлбөр гаргуулах үндэслэлтэй гэж үзэж байна гэв.
17.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.07.16 Дугаар: 181/ШШ2019/0152 6 Товч агуулга: МДХХК-иас 22.336.800 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэгч Б.М-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн.	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 22.336.800 төгрөг гаргуулах тухай	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 9/1690 дугаартай албан бичигт даатгалын тохиолдол хэрхэн үүссэн болох нь тогтоогдохгүй байх тул нөхөн төлбөртэй холбоотой маргааныг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариуг явуулсан.
18.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.07.02 Дугаар: 01471	Удирдах ажилтны хариуцлагын даатгалын гэрээний дагуу	Хариуцагч “Б” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь даатгалын тохиолдол гэж	Санхүүгийн зохицуулах хорооноос Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд зааснаар

	Товч агуулга: Хариуцагч “Б” ХХК-иас бүгд 67 881 486/жаран долоон сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун наян зургаа/ төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч “Э” ХК-д олгохоор шийдвэрлэсэн.	даатгалын нөхөн төлбөрт 67 881 486 төгрөгийг гаргуулах тухай.	үзэхгүй, нэн даруй мэдэгдээгүй гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	2018 оны 06 дугаар сарын 26-ны өдөр оролцогчийг сонсох ажиллагаа явуулахад даатгагчид бодитоор эдийн болоод эдийн бус ноцтой хохирол учирсан хэмжээ нь тогтоогдоогүй тул даатгагч нь даатгалын гэрээний дагуу даатгуулагчид нөхөн төлбөр олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.
19.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.06.17 Дугаар: 181/ШШ2019/0138 1 Товч агуулга: Нэхэмжлэгч Б.З гийн “Б Д ” ХХК-нд холбогдох даатгалын нөхөн төлбөрт 11 490 200 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн.	Аялалын даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөр 11 490 200 төгрөг гаргуулах тухай.	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Нэхэмжлэгч нь Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргасан боловч гомдлыг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн.
20.	Шүүх: ЧДИХАШШ Огноо: 2019.06.05	Гадаад ачаа тээврийн даатгалын	Б ХХК нь даатгалын нөхөн төлбөр	Санхүүгийн зохицуулах хороо 2019 оны 02 дугаар

	Дугаар:182/2019/01060 Товч агуулга: Хариуцагч Б ХХК-иас 55,330,126 /тавин таван сая гурван зуун гучин мянга нэг зуун хорин зургаа/ төгрөг гаргуулж нэхэмжлэгч Б ХХК-нд олгохоор шийдвэрлэсэн буюу нэхэмжлэлийн үнийн дүнг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр нэхэмжлэл гаргасан өдрийн ханшаар тооцож хангасан.	гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөр 75,330,126 төгрөг гаргуулах тухай.	70,466,472 төгрөгийг хэсэгчлэн төлж, үлдэх 4,863,654 төгрөгийг төлөхгүй гэж маргаж байна.	сарын 19-ний өдрийн 9/526 тоот албан бичгээр анхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасныг үндэслэн шийдвэрлэхэд, Иргэний хуулийн 439 дүгээр зүйлийн 439.4, Даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, даатгалын гэрээний 5 дугаар зүйлийн 5.2.1-д заасны дагуу даатгалын нөхөн төлбөрийг олгож, уг шийдвэрийг биелүүлсэн эсэх талаараа тус Хороонд 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн дотор хариу мэдэгдэх"-ийг даалгаж шийдвэрлэсэн байна.
21.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.05.28 Дугаар:01253 Товч агуулга: Хариуцагч “А” ХК-иас нийт 8 000 000/найман сая/ төгрөгийг	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 10 000 000 төгрөгийг гаргуулах тухай.	“А” ХК нь гал түймэр гарсан шалтгааныг даатгуулагч бүрдүүлсэн гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос шийдвэрлэх боломжгүй гэсэн тодорхойгүй хариу өгч шүүхэд хандахыг зөвлөсөн.

	гаргуулан нэхэмжлэгч С.Өд олгож, үлдсэн 2 000 000/хоёр сая/ төгрөгийг хэрэгсэхгүй болгохоор шийдэрлэсэн буюу нэхэмжлэлийн шаардалгыг хэсэгчлэн хангасан.			
22.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.05.23 Дугаар: 1211 Товч агуулга: М Д ХХК-иас даатгалын нөхөн төлбөрт 47.979.806 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч М.И од олгохоор буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	Амь насны даатгалын гэрээний дагуу даатгалын гэрээний нөхөн төлбөрт 47,979,806 төгрөгийг гаргуулах тухай.	Хариуцагч нь даатгалын гэрээний 8.7-д зааснаар ходоодны хорт хавдар нь архаг хууч өвчинд хамаарна гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос 2018 оны 04 дүгээр сарын 12- ны өдрийн 9/1941 тоот албан бичгээр “Даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй байна” гэсэн хариуг ирүүлсэн.
23.	Шүүх: СБДИХАШШ Огноо: 2019.04.01 Дугаар: 0785 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангасан.	Гэнэтийн ослын даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 35,842,656.8 0 төгрөг гаргуулах тухай	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	Санхүүгийн зохицуулах хорооноос 2018 оны 7 дугаар сарын 02- ны өдрийн 9/2904 албан бичгээр “нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосон хэмжээгээр олго” хэмээн шийдвэрлэсэн.
24.	Шүүх:	Зээлийн	Нэхэмжлэлийн	Санхүүгийн

	СБДИХАШШ Огноо: 2019.01.11 Дугаар: 00263 Товч агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангасан.	эрсдэлийн даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөрт 14,879,336 төгрөг гаргуулах тухай	шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй.	зохицуулах хорооны зүгээс 2018 оны 10 сарын 16-ны өдрийн 9/4038 дугаар албан бичгээр иргэний журмаар шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ үү хэмээн шийдвэрлэсэн.
--	---	---	--	--